

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018.04.26

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2018.4.26 ний өдрийн 13 цагт бүртгэл эхэлж, 14цаг 20 минутад Компанийн танхимд болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2018.04.16 ний өдрийн “Хүчин төгөлдөрт тооцох тухай” №01тоот тогтоолыг уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Болортуяа : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3800721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9368 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий ширхэг хувьцаа эзэмшсэн 519 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 56 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа Хурлын дарга Л.Янжин : Хурлын тэргүүлэгч, нарийн бичгийн даргаар хэн, хэнийг хэдэн хүнээр сонгох саналтай байгаа талаар асуухад :

Хувьцаа эзэмшигч Найрамдал: Хурлын даргыг ТУЗ өрийн тогтоолоор томилсон байна, харин тэргүүлэгчдээр Мөнхбаяр, Тэрбиш нарыг, нарийн бичгийн даргаар И.Өлзийбаяр нарыг сонгох саналтай байна гэв. Хувьцаа эзэмшигчид уг саналыг 100% санал нэгтэй баталж, хурлын дарга, тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг ажилдаа орохыг урив.

Хурлын дарга хурлын дэгийг танилцуулж, дэгийг хуралд оролцогч нар 100% санал нэгтэй батлав. Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах
2. 2018 оны зорилт, төлөвлөгөөг батлах
3. ТУЗ-ийг сонгох, 2018 оны ТУЗ-ийн төсвийг батлав
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
 1. Компанийн 2017 оны тайланг ТУЗ-ийн хараат бус гишүүн Лхачинбал
 2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд өгсөн ТУЗ –ийн дүгнэлтийг ерөнхий нягтлан бодогч Батсүх
 3. Компанийн 2018 оны зорилт, төлөвлөгөөг ХКҮ-ийн дарга Бадмаа нар тайлагнав.

5

Үүний дараа ТУЗ-д нэр дэвшигчдийг танилцуулав. Шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Даянбилгүүн нэрээ дэвшүүлж байна гээд товч намтрыг уншиж өгөв.

Хурлын дарга: Одоо санал, шүүмжлэлдээ оръё, хэнд ямар санал, шүүмжлэл байна вэ?

Хувьцаа эзэмшигч Нямжаргал: Хурлын явцыг харахад өмнөх жилүүдийнхээс илүү сайн боллоо, илтгэлүүдийг сайн бэлдсэн байна, ашигладаггүй байсан үл хөдлөх хөрөнгүүдийг түрээсэлж эзэнтэй болгосон байна, би баяртай байна. Би өнөөдөр танилцах материалыг авлаа, өмнө нь танилцаж чадсангүй, бас хурлыг өнөөдөр болно гэдгийг өглөө л мэдлээ. Өмнө нь яаж мэдэх ёстой вэ? Бас санхүүгийн тайланд хэвлэлт, бичилтийн алдаа юу? Орон дээр алдаатай байна?

Ерөнхий нягтлан бодогч Батсүх: Хэвлэлтийн алдаанаас тооны оронг буруу бичсэн байна, уучлаарай, бид дахин ийм алдаа гаргахгүй байхыг хичээн ажиллая, гэхдээ би тайландаа зөвөөр тайлбараа өгсөн.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр: Манай компанийн ТУЗ хуралдаж тогтоол гаргасан. Уг тогтоолдоо ямар ямар бичиг баримттай танилцаж болох уу? Уг баримтуудыг хэзээ бэлэн болгох талаар болон зохион байгуулах комисс, тооллогын комисс, хурал даргалагчийг томилсон байгаа, бид тайлангуудыг бэлэн болгож, өөрийн компани дээр танилцаж болно гэдгийг дурьдсан, зарим нэг хувьцаа эзэмшигч нар ирж танилцаж, танилцуулгыг авсан болно. Хурлын товыг хэвлэл мэдээлэл болон телевизороор тус бүр 2-3 удаа явуулсан, мөн хөрөнгийн бирж болон өөрийн компанийн вэйп сайтад тавьсан болно.

Хувьцаа эзэмшигч Гончигсүрэн: Компанийн ажил идэвхижиж сайжирсан байна. Мөн компанийн тохижилт, өнгө үзэмж сайжирчээ. Үйл ажиллагаа тогворжсон байна. Би ерөнхий нягтлан бодогчоос:

1. Ногдол ашиг цэвэр ашгийн хэдэн хувийг эзэлж байна, ер нь хэдэн хувийг хуваарилах ёстой юм бэ?
2. Ногдол ашгийг яагаад 10 сараас эхлэн өгнө гэсэн юм бэ? Өнөөдрөөс өгч болохгүй юм уу?
3. Ногдол ашиг яагаад өсөхгүй байна, сүүлийн 2-3 жил нэгж хувьцаанд 100 төгрөг л байна.
4. Зарыг телевизороор сайн явуулмаар байна, бид нар шиг хөгшчүүл тэр болгон сонин аваад байж чадахгүй юм. Би гэхэд телевизороор явж байгаа үгэн зараар мэдэж хуралдаа ирсэн.

Ерөнхий нягтлан бодогч Батсүх: Ер нь ногдол ашиг хуваарилж байгаа хувьцаат компаниудыг судлан үзэхэд татвар төлсний дараах цэвэр ашгийн 20 % ийг ногдол ашиг тараахад зарцуулж байна. Манай компанийн хувьд энэ жил цэвэр ашгийг тэр чигт нь ногдол ашигт хуваарилахаар шийдвэрлэсэн, тэр бол хувьцаа эзэмшигчдээ хандсан бодлого, тэгэхлээр бид бусад зардалд зарцуулах зардлыг үйл ажиллагаа болон борлуулалтын

зардлаас олно гэж тооцоолсон, ийм учраас 10-р сараас олгоно, гэсэн юм, өөрөөр хэлвэл 10-р сараас олгох боломж бүрдэнэ гэсэн үг. Цэвэр ашгийн 20% ийг тараана гэвэл 100 төгрөгнөөс бага төгрөг гарсан тул нэмэхгүй юм аа гэхэд багасгахгүй гэсэн бодлого барьсан юм. Үйл ажиллагаа тогтворжиж үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэхийн хирээр ногдол ашиг нэмэгдэнэ, үүний төлөө л бид ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Туул: Би МУ-ын ерөнхийлөгчийг энэ компанийн том хувьцаа хувьцаа эзэмшигч гэж сонссон, хөрөнгө оруулалтыг татаж, үйлдвэртээ их зүйл хийгээсэй, тэр чинээгээр ногдол ашиг өснө гэж боддог, ажлын амжилт хүсье гэв

Хурлын дарга Л.Янжин : өөр санал хүсэлт хэлэх хүн байна уу? Байхгүй бол санал шүүмжлэлээ таслах уу? Гэхэд бүгд зөвшөөрлөө. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Болортуяа "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалын..... хуудсанд хавсаргав.

Компанийн нийт **3800721** ширхэг хувьцаа эзэмшиж буй **9681** хувьцаа эзэмшигчдээс хуралд **2169511** ширхэг хувьцаа эзэмшиж байгаа **519** хувьцаа эзэмшигчид оролцов.

Тооллогын комиссоос тараасан саналын хуудас **519** ширхэг, хураан авсан саналын хуудас **411** ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо **2132644** буюу нийт саналын **56.11 %**, асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо **36867** буюу нийт саналын **0,97%** байна.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн~~2~~..... ширхэг хувьцаа буюу нийт саналын~~2~~ хувь.
2. Компанийн 2018 оны зорилт, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан~~2~~..... ширхэг хувьцаа буюу нийт саналын~~2~~ хувь, түдгэлзсэн~~2~~..... ширхэг хувьцаа буюу нийт саналын~~2~~ хувь.
3. Компанийн ТУЗ-ын ердийн гишүүнээр:

- Ж.Чинзоригийг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан~~2~~..... ширхэг хувьцаа

буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа
буюу нийт саналын ~~...2~~ хувь.

- Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Ж.Баттөрийг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Л.Янжинг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Д.Жанчивдоржийг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- М.Баттогтохыг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~5~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~0,0002~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Н.Лхачинбалыг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~5~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~0,0002~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.
- Ц.Цолмонг сонгохыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь, түдгэлзсэн ~~...2~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...2~~ хувь.

- Д.Даянбилгүүнийг сонгохыг зөвшөөрсөн ¹⁰ ширхэг хувьцаа буюу нийт саналын ^{0.00046} хувь, татгалзсан ^{213,2634} ширхэг хувьцаа буюу нийт саналын ^{98,3} хувь, түдгэлзсэн ^{...} ширхэг хувьцаа буюу нийт саналын ^{...} хувь.

4. 2018 оны ТУЗ-ийн зардлын төсөв батлахыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь.
5. Ногдол ашиг хувиарлахыг зөвшөөрсөн 2132644 ширхэг хувьцаа буюу нийт саналын 98,3 хувь, татгалзсан ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь.

ирснийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Дээрхи хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Үүний дараа тооллогын комиссын дүнг үндэслэн хувцаа эзэмшигчдын хурлаас ТОГТООХ НЬ:

1.Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2018 оны зорилт, төлөвлөгөөг баталсугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

- Ж.Чинзориг
- Д.Цэнддорж
- Х.Цэндбаяр
- Л.Янжин
- Д.Жанчивдорж
- Ж.Баттөр

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр

- Ц.Цолмон
- М.Баттогтох
- Н.Лхачинбал нарыг 3 жилийн хугацаатай сонгосугай

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлыг баталсугай

5. Нэгж хувьцанд оногдох ноогдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосугай гэсэн тогтоолыг уншиж танилцуулахад хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтэй батлав. Үүгээр хурлын ажиллагаа 16 цаг 10 минутад өндөрлөв.

Хуралын дарга

Л.Янжин

Тэмдэглэсэн

И.Өлзибаяр

